



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 675
танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Л.Цэрэнхандын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021354

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Л.Цэрэнханд Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Л.Цэрэнхандын мөрийн хөтөлбөр (.....(.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Л.Цэрэнхандад

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ СУМЫН ХҮРЭМТ БАГИЙН 2024 ОНЫ ИТХ-ЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Л. ЦЭРЭНХАНДЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

1. Эрүүл мэнд

- 1.1 Ард иргэдийн шүдний үзлэгт хамрагдалт дээр хяналт тавих
- 1.2 Эрт илрүүлэгт хамрагдсан иргэдийн судалгааг гаргах
- 1.3 Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхийг уриалах
- 1.4 Хүнсний аюулгүй байдалыг сурталчилах
- 1.5 ЕБС-ийн сурагч нар улирал тутам халдвар өвчнөөс сэргийлэх, шүдний эрүүл ахуй, зөв хоололт, хөдөлгөөний ач тусын сургалт зохион байгуулах

2. Жижиг дунд үйлдвэрлэл

- 2.1 Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх иргэдийн судалгааг гаргах
- 2.2 Төмс хүнсний ногоо тариалахыг сурталчилах
- 2.3 Фермерийн аж ахуйн ач тусыг таниулах
- 2.4 Оёдлын цехийн үйл ажиллагаанд хяналт тавих

3. Байгаль орчин

- 3.1 Булаг шандыг хашиж мод тарих ажлыг эрчимжүүлэх
- 3.2 Нийтийн хогийн цэг байрлуулахыг шаардах
- 3.3 Ойжуулалт, ногоон байгууламж нэмэгдүүлэхийг дээд шатны байгууллагад уламжлах
- 3.4 Золибон нохой, муурай устгах ажилд хяналт тавих
- 3.5 Сумын төвийн замыг сайжруулах, үерийн усны шуудуу татахыг удирдах шатанд шаардлага хүргүүлэх

Мөрийн хөтөлбөр боловсруулсан: Лхагвасүрэн Цэрэнханд

Холбоо барих утас: 99678671